



ЗӨВЛӨМЖ

#1. ЗӨВЛӨМЖ

Засаг даргын нөөц хөрөнгийг хэт үрэлгэн, зориулалт бусаар зарцуулж байгааг таслан зогсоох, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдлээс урьдчилан сэргийлэх талаар холбогдох хууль, журмыг боловсронгуй болгоход чиглэсэн санал санаачилгыг хэрэгжүүлэх, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах.

Баян-Өлгий аймгийн хэмжээнд Засаг даргын нөөц хөрөнгийг холбогдох журмын дагуу зарцуулж хэвшүүлэх, нөөц хөрөнгийн санхүүжилтээр хүлээн авалт, дайллага, цайллага хийх явдлыг таслан зогсоох, нөөц хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгахыг анхаарч ажиллах чиглэлээр тодорхой арга хэмжээ аваагүй байна.

Нөөц хөрөнгийг журмын дагуу аймгийн ИТХ-аас 2017 онд 313.080.000 төгрөгөөр, 2018 онд 269.600.000 төгрөгөөр тус тус баталсан байх бөгөөд 2017 онд үлдэгдэлгүй зарцуулжээ. Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3.1-д “Засаг даргын нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулах”-аар заасан байтал 2017, 2018 онуудад Засаг даргын зөвлөлөөр нөөц хөрөнгийн зардлыг хэлэлцүүлэлгүйгээр захиран зарцуулсан байна. Засаг даргын нөөц хөрөнгийг төсвийн хууль тогтоомжийн дагуу төлөвлөсөн боловч зарцуулахдаа Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах нийтлэг журам”-ыг баримтлаагүй шагнал урамшуулал, уралдаан тэмцээн, хүндэтгэл үзүүлэх зэрэг зориулалтын бус арга хэмжээнд зарцуулах зөрчлүүд давтагдсаар байна. Тухайлбал, АТГ-ын 2017 онд ажилласан ажлын хэсгийн хүрээнд илэрсэн орон нутагт албан томилолттой ирсэн төрийн албан хаагчдад Засаг даргын нөөц хөрөнгөөс гарын бэлэг бэлтгэх, хоол хүнс, шатахуун унааны зардал зэрэгт 15.968.239 төгрөгийг зарцуулжээ.



#1. ЗӨВЛӨМЖ

Өмнөх онд дээрх чиглэлээр Авлигатай тэмцэх газраас зөвлөмж хүргүүлсэн байтал орон нутагт албан ажлаар ажиллаж буй албан тушаалтнуудын хоол, буудлын үнийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргах явдал хэвээр байгаад удирдах албан тушаалтан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх хүчин чармайлт гаргах, хүсэл зориг гаргаагүй гэж үзэхээр байна.

Засаг даргын нөөц хөрөнгийн 48,1 хувийг буюу 151.0 сая төгрөгийг 2017 онд урьдчилан тооцох боломжгүй цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээний зардалд зарцуулсан нь холбогдох журмын шаардлагыг хангахгүй байна. Түүнчлэн 16.0 сая төгрөгийг шагнал урамшуулалд, 34.7 сая төгрөгийг гадаад, дотоодоос ирсэн зочин төлөөлөгчийг хүлээж авах зардалд, 23.7 сая төгрөгийг олон улсын болон улс орон нутгийн чанартай уралдаан тэмцээний зардалд, 76.6 сая төгрөгийг бусад арга хэмжээний зардалд, 2018 онд 57.1 сая төгрөг буюу 26 хувийг шагнал, урамшуулал, хүндэтгэл үзүүлэхэд, 50.100.000 төгрөг буюу 23,03 хувийг буцалтгүй тусламж, дэмжлэгт, 61.2 сая буюу 28,5 хувийг бусад арга хэмжээнд зарцуулжээ. **(Хавсралт 1).**



Тус аймгийн Засаг даргын 2017 оны А/364 дүгээр захирамжаар Үндэсний баяр наадмыг зохион байгуулах зардалд 17.659.700 төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөр, 2018 онд 19.865.700 төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолоор Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоосон /бөх, уяач, харваачдад төсвөөс олгох бай, шагналын жишиг хэмжээнд ЗГ-ын 2014-6-14-ний 194-р тогтоолоор өөрчлөлт орсон/-ыг зөрчин жишигт хэмжээг 2017 онд 7.659.700 төгрөгөөр, 2018 онд 9.865.700 төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна. Аймгийн Засаг даргын 2017 оны А/141, А/142 дугаар захирамжаар 4 973 000 төгрөгийг зөвхөн Наурыз баяр тэмдэглэхэд, 2017 оны А/729 дүгээр захирамжаар Шинэ жилийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэхэд 5.990.000 төгрөгийг, 2017 оны А/421 дүгээр захирамжаар Засаг даргын албаны автомашинд андройд дэлгэц, ухрахын камер суурилуулахад 850.000 төгрөгийг тус тус Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсан байна.

#2. ЗӨВЛӨМЖ

Төсвийн хөрөнгөөр баяр наадам, тэмдэглэхдээ тогтоосон журам, дүрмийг баримталж хэвшүүлэх, шаардлагатай тохиолдолд төсвөөс гарах санхүүжилтийн жишиг хэмжээнд өөрчлөлт оруулах асуудлыг судлан шийдвэрлүүлэх замаар холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, төсвийг, үр ашиггүй зарцуулахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ авах.



#3. ЗӨВЛӨМЖ

Аймгийн тендерийн ажиллагааг хэлбэрээр санаачилгыг хэрэгжүүлэх, авах холбогдох мөрдлөг заавар, хүргүүлэх, төсөв хийгдсэн хэмжээг оруулалтын төлөвлөгөөнд хэрэгжүүлж төстэй хэмжээг багцалж харьцуулалтын ашиглахаас **хэмжээнд үйл цахим явуулах худалдан ажиллагаанд журмыг талаар чиглэл ТЭЗҮ, зураг, иж бүрэн төсөл арга хөрөнгө тусган ижил төсөл арга нэгтгэн төлөвлөх, аргыг**

Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авалтуудыг зохион байгуулж гүйцэтгэлийг тооцон ажилласан боловч Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, 2016 оны 415 дугаар “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын хэрэгжилт үр дүн муутай байна. Тухайлбал, тус аймгийн Дэлүүн сумын эмнэлгийн дээврийн шувуу нурууны засварын ажил, Толбо сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн их засварын ажлуудад тендер сонгон шалгаруулахтай холбоотой иргэдээс гомдол гарч дахин үнэлгээ хийжээ.

Толбо сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, Өлгий сумын 5 дугаар баг, Спортын талбай, Өлгий сумын 8 дугаар цэцэрлэгийн барилгын ажил, Толбо сумын 100 хүүхдийн цэцэрлэг, тоглоомын талбай, Буянт сумын халуун усны барилгын ажил, аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулах ажил, Алтанцөгц сумын Сургуулийн хатуу, зөөлөн эдлэл, Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, Услалтын систем /Баян-Өлгий, Алтай сум/, Үерийн усны хамгаалалтын далан сувгийн эхний ээлжийн ажил 16 км /Баян-Өлгий, Өлгий/, цэцэрлэгийн барилга, 125 ор /Баян-Өлгий, Сагсай сум/, Орон нутгийн судлах музейн засвар зэрэг ажлуудад Сангийн яаманд гомдол гаргасан байна. Үүнээс 1 тендер захиалагчийн талд шийдэгдсэн байх ба 1 тендер шүүхэд гомдол гарсан бусад тендерүүд бүгд дахин үнэлгээгээр шийдвэрлэгдсэн байна.



#3. ЗӨВЛӨМЖ

аль болох зайлсхийх, төсөл арга хэмжээний хэрэгцээ, шаардлага, хөрөнгийн эх үүсвэрийг бодитоор тооцсоны үндсэн дээр хуулиар тогтоосон хугацаанд төлөвлөж батлуулах, төсөл арга хэмжээний хэрэгжилтэнд дотоод хяналтыг сайжруулах, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, болон худалдан авалттай холбоотой шаардлагатай мэдээ мэдээллийг ил тод болгож сайтад байршуулдаг тогтолцоог бүрдүүлэх.

Түүнчлэн Өлгий сумын 8 дугаар цэцэрлэгийн барилгын ажлын тендерт “Ёлт констракшн” ХХК хуурамч материал тендерт ирүүлснийг тогтоосон боловч хар жагсаалтад оруулаагүй, Өлгий сумын 11 дүгээр багт шинээр татах цэвэр усны гол магистрал шугамын ажлын тендерт 2 аж ахуйн нэгжээс үнийн санал авч, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн баримт байхгүй үндэслэлээр бага үнийн санал ирүүлсэн аж ахуйн нэгжийг сонгоогүй. Бөхөн уулын бэлд замын пост байгуулах тендерт 2016 оны санхүүгийн тайлан, инженерийн дипломгүй “Цамбагарав” ХХК шалгаруулсан байна.

Аймгийн мал хамгаалах санд өвс авах ажлын тендерт “Сайхан тэвсэг” ХХК дангаар оролцож шалгарсан байна. Уг тендерийг зарлаж өгөхийг хүссэн албан бичгийн төсөвт өртгийн тоог засварласан, тендерийн ажлын даалгаврын өвс худалдан авах тоо хэмжээ, үнийн дүнг мөн засаж, худалдан авалт зохион байгуулсан байна.

Булган суманд хэлмэгдэгсдийн хөшөө байгуулах 40.000.000 төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны нарийн бичиг дарга Х.Бахытгүл нь аймгийн иргэдийн Хурлын төлөөлөгч, Автотээврийн үндэсний төвийн дарга А.Сайдолдагийн хууль бус шаардлагаар түүний үүсгэн байгуулсан “Асгат кент” ХХК-тай, аймгийн Засаг даргын орлогч А.Камалият шууд гэрээ байгуулсан байна. /Тус ажил 2018 оны 09 дүгээр сард дуусч гэрээ дүгнэхээр байсан боловч одоог хүртэл дүгнэсэн гэрээ байхгүй/.



#4. ЗӨВЛӨМЖ

Үнэлгээний иргэний төлөөлөлтэй байгуулах шаардлагыг Үнэлгээний гишүүдийг ашиг зөрчлөөс мэргэшсэн хаагчдаар тэдгээрийн байгууллага нэмэгдүүлэх, тэднийг сургах, чадавхижуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах.

Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2017 онд А/322, А/313, А/337, А/443, А/444, А/485, А/715, А/694, А/676, А/313, А/333 дугаар, 2018 онд 23, 30, 69, 207, 210, 213, 254, 255, 260, 280, 314 дүгээр захирамжаар тус тус Үнэлгээний хороог байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулий 47 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын 2-оос доошгүй төлөөлөгч оролцуулах” гэж заасныг мөрдөөгүй байна. АТГ-аас энэ чиглэлээр өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргахгүй байх чиглэлээр тодорхой арга хэмжээ аваагүй байна.



Ажлын хэсэг ажиллах явцдаа аймгийн иргэдийн Хурлын Тэргүүлэгчдээс орон нутгийн өмчийн хөрөнгийг түрээслэх, түрээсийн доод үнэ болон зөвшөөрлийн үнэ, улсын тэмдэгтийн хураамж, хууль бус нэмэлт төлбөр тогтоосон, тариалангийн бүс хязгаар, модны дээд хязгаар тус тус баталсан, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлээгүй 5 тогтоолыг мөрдүүлж буй зөрчлийг илрүүлж, хүчингүй болгуулав. Тухайлбал, аймгийн ИТХТ-ээс 2011 оны 87 дугаар тогтоолоор улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг, 2017 оны 100 дугаар тогтоолоор аймгийн баяр наадмын тээврийн хэрэгслийн зөвшөөрлийн үнийг, 2017 оны 42 дугаар тогтоолоор аймгийн тариалангийн бүсэд хамрагдах сум талбайн хэмжээг, 2017 оны 17 дугаар тогтоолоор ахуйн зориулалтаар агнах, барих агнуурын загасны тоо хэмжээг, аймгийн нутаг дэвсгэрт ойн сангаас бэлтгэх модны хэмжээг тус тус батлахын зэрэгцээ “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх журам”-ыг Хууль зүйн яамны нэгдсэн бүртгэлд бүртгүүлээгүй байв. Аймгийн ИТХТ-ийн тогтоолоор зөвшөөрөл өгч нийт 80 500 000 төгрөгийн хөрөнгийг холбогдох хуульд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай зөвшилцөж шийдвэрлэлгүйгээр худалдсан байна.

#5. ЗӨВЛӨМЖ

Аймгийн хэмжээнд хуулиар эрх олгогдсоноос бусад этгээд дүрэм, журам батлах, хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэлгүй мөрдлөг болгох, үндэслэлгүй төлбөр хураамж тогтоох зэрэг зөрчлийг таслан зогсоох чиглэсэн үүрэг, даалгавар хүргүүлэх, хэрэгжилтийг үе шаттай хянах механизм бүрдүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авах.



#5. ЗӨВЛӨМЖ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар төрийн өмчийг худалдах асуудал уг хуулийн 29, 31, 77, 80 дугаар зүйлүүдээр зохицуулагдаж байх бөгөөд хуулийн зохих заалтуудын хүрээнд орон нутгийн өмчийн хөрөнгийг заавал дуудлага худалдаагаар худалдах, орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг хувьчлах ба бусдад шилжүүлэх, шинээр олж авах жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийг хэлэлцэж батлах, хувьчлах орон нутгийн эд хөрөнгийн жагсаалтыг батлахдаа Төрийн өмчийн хороотой зөвшилцөнө, орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү ИТХ, түүний хуралдааны чөлөөт цагт ИТХТ шийдвэрлэнэ гэж заасан байхад нийт 33.750.000 төгрөгийн хөрөнгийг дуудлага худалдаа явуулалгүйгээр шууд худалдсан байна.

Мөн аймгийн Засаг даргын 2013 оны 503 дугаар захирамжаар тусгай зөвшөөрлийн гэрчилгээг дахин шинэчлэн олгох журмыг баталсан байх бөгөөд энэхүү журмын 2.1.5 дахь хэсгээр тусгай зөвшөөрлийг эзэмшихтэй холбогдох баримт бичгийн бүрдэлд гэрчилгээний үнэ 5.000 төгрөгийг иргэн_аж ахуйн нэгж төлөхөөр зохицуулсан нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчиж байна.



Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний талаар багийн иргэдийн Нийтийн Хурлаар эрэмблэгдсэн саналуудаас аймгийн чиг үүрэг бүхий саналуудыг авч, аймгийн ИТХТ-өөс санал авч эрэмбэлсэн байх боловч хугацааны хувьд 5 дугаар сард багтаах ёстой байтал 6-12 дугаар сард зохион байгуулсан байв. Аймгийн 2018 оны төсвийг батлахдаа Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг Үндэсний их баяр наадам тэмдэглэхэд зарцуулахаар төсөвлөөгүй байх бөгөөд харин сангийн хөрөнгийг зарцуулах төлөвлөгөөнд тусгагдаагүй ажилд буюу Нэгдсэн эмнэлэгт Нярайн эх барихын цомог худалдан авахад 26.505.000 төгрөгийг бүрэн автомат угаалгын машин 2 ширхэгийг 2.360.000 төгрөгөөр нийт 28.865.000 төгрөгийг, Бөхөн уулын даваанд 220 м гүний худгийг зээлийн хөрөнгөөр хийлгэх болсон тул материал худалдан авахад зориулан 6.000.000 төгрөгийг эргэн төлөх нөхцөлтэйгээр Засаг даргын орлогчийн 2017 оны А/503 дугаар захирамжаар, Засаг даргын орлогчийн 2017 оны А/501 дүгээр захирамжаар 7.754.300 төгрөгийг эргэн төлөх нөхцөлтэйгээр аймгийн Засаг даргын хүндэт тэмдгийг хийлгэх үйл ажиллагааны зардалд тус тус гаргасан боловч энэ оны байдлаар уг зардлууд эргэн төлөгдөөгүй байв. Мөн 2017, 2018 онуудын ОНХС-ийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байтал аймгийн ИТХТ-дийн 2018 оны 58 дугаар тогтоолоор аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын сангаас 10.800.000 төгрөгийг аймгийн Эрүүл мэндийн газарт 6 ширхэг мотоцикл авахад зарцуулахаар шийдвэрлэсэн нь Орон нутгийн хөгжлийн сангийн журамд “Засаг дарга нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг тухайн жилийн төсвийн төсөлд тусган аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.” гэснийг хангахгүй байна.

#6. ЗӨВЛӨМЖ

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, холбогдох хууль журмын дагуу зарцуулаагүй байдалд хариуцлага хүлээлгэж хэвшүүлэх, төсвийн хөрөнгийг зориулалтын бус зарцуулахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ авах.

**#7. ЗӨВЛӨМЖ**

Төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, албан тушаалтны хариуцлагыг дээшлүүлэх, төсөв хөрөнгийг холбогдох эрх байгууллагаас гаргасан заавар, чиглэл, шийдвэрийн дагуу зарцуулж байх.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын дарга харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх бүрэн эрхийг тодорхой заасан байх бөгөөд Төсвийн тухай хуулийн 16.4.14-т “аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн шууд захирагч” байхаар, мөн хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” бүрэн эрхийг бүх шатны Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичиг дарга хэрэгжүүлэхээр заасан байна. Гэтэл аймгийн ИТХТ-ийн 2017 оны 32 дугаар тогтоолоор журам батлан хурлын төсвийг Тэргүүлэгчдийн тогтоолоор 2017 онд Хурлын даргын цэрэг стратеги бэлтгэл хангах сургалтын хувцасны үнэд 1.647.000 төгрөгийг, сургалтын зардалд 3.250.000 төгрөгийг, “Эмэгтэйчүүдийн ТББ”-ын нэгдсэн сүлжээнд 1.000.000 төгрөгийг, “Арулар холбоо”-ны 10 жилийн ойн арга хэмжээнд 500.000 төгрөгийг, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 25 жилийн ойн арга хэмжээнд 500.000 төгрөгийг, 2018 онд хүчит бөхийн барилдааны шагналд 2.550.000 төгрөгийг гэх мэтээр баяр наадам тэмдэглэх, шагнал урамшуулал, тусламж дэмжлэг олгох, Хурлын даргын хэрэгцээ зэрэгт зарцуулжээ.



#7. ЗӨВЛӨМЖ

Аймгийн хурлын төсвийг дээрх зориулалтаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нөөц хөрөнгийн төсөв тусдаа батлуулах, төсвийг Хурлын дарга зарцуулах асуудал Төсвийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх талаар Төсвийн асуудал эрхэлсэн төв байгууллагаас санал, зөвлөмж авах, төсөв хөрөнгийг зарцуулах үйл ажиллагааны чиглэлийг иргэдээр хэлэлцүүлэх, төсвийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид зарцуулах эсэх зэргийг судлан үзэж, холбогдох эрх бүхий байгууллагаас заавар, чиглэл авсаны үндсэн дээр хэрэгжүүлэх нь зүйтэй байна.



#8. ЗӨВЛӨМЖ

Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/123 дугаар тушаалаар баталсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг хэрэгжүүлэх, заасан хугацаанд холбогдох мэдээллийг ирүүлж хэвших.

Захиргааны ерөнхий хуулийн шаардлагад нийцүүлэн “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг шинэчлэн боловсруулж, Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/123 дугаар тушаалаар баталсан бөгөөд уг журам нь захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 4036 дугаартай бүртгэгдсэн (журмыг <https://www.legalinfo.mn/law/details/13778?lawid=13778> -ээс татаж үзэх).

Журмын 4.1-д “Албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан талаарх мэдээллийг холбогдох этгээдэд хүргэсэн болон нийтэд мэдээлсэн өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор журмын 2.1, 3.1-д заасан мэдээллийг тухайн албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэр (хуулбар)-ын хамт эсхүл холбогдох мэдээллийг цахим хэлбэрээр Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.” гэж заасныг мөрдөж ажиллах шаардлагатай.



Төрийн албанд иргэнийг сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ мерит зарчмыг удирдлага болгохгүй байна. Тухайлбал, Баян-Өлгий аймгийн Засаг даргын захирамжаар болон Засаг даргын дэргэдэх газрын даргын тушаалаар төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөхдөө хууль тогтоомжийн дагуу удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтгүйгээр 27 албан тушаалтныг, төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалтад ороогүй 17 албан хаагчийг түр томилсон байна (**Хавсралт 2**).

#9. ЗӨВЛӨМЖ

Төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаалаас нь бууруулсан, төрийн албанаас чөлөөлсөн, халсан, өөр албан тушаалд сонгогдсон, томилогдсоны улмаас гарсан сул орон тоог нөхөх буюу удирдах албан тушаалд дэвшүүлэхдээ хуульд заасан үндсэн шалгуур, зарчим, журмыг баримтлах, энэ талаарх мэдээллийг иргэд олон нийтэд байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбараар ил тод, нээлттэй болгох.



Төрийн мэргэшсэн албан хаагчийг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлдөг зөрчил арилаагүй байна.Тухайлбал, Баян-Өлгий аймгийн хэмжээнд 2018 онд шүүхийн шийдвэрээр эргэн томилогдсон Орон нутгийн өмчийн газар, Эрүүл мэндийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын нийт 12 албан хаагчид 41.327.435 төгрөгийн нөхөн олговор олгосон байна (Хавсралт 3).

#10. ЗӨВЛӨМЖ

Төрийн мэргэшсэн албан хаагчдыг зөвхөн хуульд заасан үндэслэлээр ажлаас чөлөөлөх, үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлсний улмаас учирсан хохирлыг хууль бус шийдвэр гаргасан буруутай этгээдээр нөхөн төлүүлэх, төрийн жинхэнэ албан тушаалын томилгоонд хяналт тавих дээд шатны болон иргэд олон нийтийн хяналтыг сайжруулах нөхцөлийг бүрдүүлэх.



#11. ЗӨВЛӨМЖ

Албан тушаалтан томилогдсоноос хойш хуульд заасан хугацаанд хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах чиглэлээр салбарын хэмжээнд зохион байгуулалтын арга хэмжээ авах, мэдүүлгээ хугацаандаа гаргаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох, хяналтыг сайжруулах.

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасны дагуу мэдүүлэг гаргагч албан тушаалтан хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн албан тушаалыг хашиж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргах үүрэгтэй. Ажлын хэсэг ажилласан байгууллагуудын хэмжээнд 2018 онд 9 албан тушаалтан хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу томилогдсон өдрөөс хойш хуулийн хугацаанд хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогоо мэдүүлээгүй, хугацаа хожимдуулж мэдүүлсэн зөрчилтэй байна.

Дээр дурдсан үүргээ биелүүлээгүй 9 албан тушаалтанд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.1-д зааснаар “хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг энэ хуулийн 23.3-т заасан хугацаанаас хожимдуулж гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол сануулах”, мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2-т зааснаар “...хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг энэ хуулийн 23.3-т заасан хугацаанаас удаа дараа хожимдуулж гаргасан бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах”, Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8.1-д зааснаар “...заасан хугацаанаас хожимдуулсан нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол сануулах” шийтгэлийг тус тус ногдуулах албан бичиг хүргүүлээд байна.



Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу үнэлгээний хорооны гишүүн болон албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж байхаар тусгасан бөгөөд дээрх зөвлөмжийн дагуу тус аймагт 2017 онд нийт 10 /давхардсан тоогоор/, 2018 онд 486 /давхардсан тоогоор/ сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл, 2018 онд тус аймгийн Засаг даргаас сумын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарыг томилох, урамшуулал олгохтой холбоотой шийдвэр гаргахдаа зөрчил үүссэх нөхцөл байдлын талаар 6 тайлбар гаргасан байна. Харин Байгаль орчин, аялал жуулчлалын газар /21/, Эрүүл мэндийн газар /11/, Мэргэжлийн хяналтын газар /5/-ын даргын тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны 37 гишүүн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл, тайлбар гаргаагүй байна.

#12. ЗӨВЛӨМЖ

Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд бичгээр мэдэгдэл гаргах, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх ажлыг хэвшүүлэх, энэ талаарх мэдээллийг иргэд олон нийтэд ил тод, нээлттэй болгох.